

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан;

Тасалсан: Н.Алтанхуяг.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдаанд оролцов.

Нэг.Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаас ирүүлсэн хүсэлтийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас Ж.Хунанг чөлөөлөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 9 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 11 цаг 39 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар Байнгын хорооны дарга, Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байна. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна. Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна. Ингээд ирц 52 хувьтайгаар ирцийн шаардлага хангагдлаа. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1 асуудал байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлага, зохион байгуулалтын асуудал. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орё. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Хунангаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцье.

Хүсэлтийг Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна. Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлаас хүний эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулж байгаа. Сүүлийн үед үүсэж байгаа хүний эрх, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлуудаар Хүний эрхийн Үндэсний Комисст тодорхой үүрэг чиглэл өгч ажиллаж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдтэй бас уулзалт хийсэн. Ингээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний уулзалтуудаас тодорхой санал гаргасан. Эндээ үндэслээд Хунан даргаас өргөдөл ирсэн байна. Танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа.

Миний бие Жаргалсайхан овогтой Хунан 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын албан тушаалд томилогдон ажиллаж байгаа бөгөөд Комиссын гишүүд Комиссын даргын албан тушаалыг цаашид радиаторын зарчмаар хаших нь зүйтэй гэдэгт санал нэгдсэн тул намайг комиссын даргын албан тушаалаас чөлөөлж, дараагийн даргыг томилуулж өгөхийг хүсье. Хүндэтгэсэн Ж.Хунан. 11 дүгээр сарын 28-ны өдөр гэсэн байна.

Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Хунангийн өргөдөл, хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Их Хурлын даргад баярлалаа. Ингээд хүсэлтийг уншиж танилцууллаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Хунангаас ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд, эс үгүй бол үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хүний эрхийн асуудал гэдэг дээр хамгийн том асуудал бол яг энэ өвлийн хүнд хэцүү цаг үед бол амьд явах эрхийн асуудал хамгийн том асуудал болчихоод байна. Ялангуяа хөдөө орон нутгийн иргэд яг энэ өвлийн хүйтэн улиралд нааш цааш явахад бол машин тэрэгний шатахууны асуудал хамгийн хүндрэлтэй асуудал болчихоод байна л даа. Манай Ховдын Дуут сум дээр сүүлийн 2 сар дизелийн түлш байхгүй. Дөргөн сум дээр 7 хоног ингээд түлш тасраад эхэлчихлээ. Тэгээд иймэрхүү байдлаар тэр нь хүмүүс чинь нааш цаашаа өвөлжсөөндөө нүүнэ, бууна. Өвс тэжээлээ татна. Тэгээд дээрээс нь амьтан ах дүү янз янзын хүмүүс өвдөнө, зовно. Тэр үед сум орон руугаа явна. Иймэрхүү асуудал дээр тэр шатахууны асуудал чинь хамгийн хүнд асуудал болчихоод байна. Үүнээс болоод бас тэр яг амьд явах эрхийн асуудал гарч ирж байна шүү дээ. Тэгээд энэ дээр Засгийн газрын гишүүд бас байх шиг байна. Энэ асуудал дээр ямар байдалтай байгаа юм бэ. Хэзээ энэ дизелийн түлш болон шатахууны хангалт бүрэн гүйцэт болох юм бэ. Тэгээд энэ чинь горимын дагуу илтгэл тавьсан хүнээс асуух байх. Тэгээд энэ дээр ямар байдалтай байгаа юм. Та хариулж өгөөч.

Д.Цогтбаатар: Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Тийм хүний асуудал ярьж байгаа. Тэгэхдээ хүний эрхийн асуудал мөн үү гэвэл мөн. Ер нь ард иргэдээс дизель түлшний хомсдол хязгаарлалттай олгож байгаа асуудлын талаар гомдол, хүсэлтүүд ирж байгаа. Энэ талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай ярьсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ганбаатар бол энэ талаар тээвэрлэлтийг зохицуулах талаар ажиллаж байгаа гэдгээ хэлсэн. Тэгээд бас намайг ОХУ-ын Төрийн думтай холбогдож өгөхийг хүссэн. Ингээд өчигдөр, уржигдар бид холбогдоод тэгээд өнөөдөр бас Засгийн газар хоорондын комиссын шинэ

даргатай уулзлаа. Өчигдөр орой надад мэдэгдэхдээ нэвтрүүлэх чадвар төмөр замын холбоотой асуудлаас болоод тээвэрлэлт саатсан байж болзошгүй байна. Түүнээс ОХУ-ын зүгээс ямарваа нэгэн хориг хязгаарлалт тавьсан зүйл байхгүй. Орос нефть компани бол бүрэн хэмжээгээр ханган нийлүүлэхэд бэлэн байгаа гэдгээ мэдэгдсэн. Тэгвэл одоо ингээд яаралтай ачуулаач гэсэн, тэгээд өнөөдөр 114 вагон 11 дүгээр сарын 29-нд хилээр орж ирнэ. Ингээд маргааш 54 вагон ингээд 29, 30, 1, 2 гэхэд нарийн графикаа танилцуулсан. Энэ нийт 350 вагоныг маргааш, нөгөөдөр, 12 сарын 2-ны өдөр хүртэл буюу ойрын 4 хоногийн хугацаанд 350 вагон дизелийн түлш орж ирснээр бол дизелийн хангамж бол бүрэн тогтворжино гэж үзэж байна. Энэ бол тээвэрлэлттэй холбоотой асуудлууд байсныг тэндээс бүр тусгай төлөөлөгч хүн хариуцуулаад төмөр замын 1 дүгээр орлогч даргад хариуцуулаад, тэгээд хаана саатаж байна, хаана төмөр замын тээвэрлэлт саатаж байна, вагон хаана саатаж байна гэдгийг бүгдийг нь хяналт тавьж ажиллахаар энэ дотроо Монголын талаас бас яг ийм хариуцсан хүн томилж төмөр замын тээвэрлэлтийн асуудал хариуцсан хүнийг томилж ингэж тээвэрлэлтийн асуудлыг хэвийн нарийн чанд графикийн дагуу явуулах асуудлаар бас ярилцаж тохиролцсон. Ийм учраас ойрын хугацаанд бол дизель түлшний хангамжийн асуудал тогтворжино. Роснефть компани дизелийн түлшний хувьд ямар ч асуудалгүй бөгөөд ямарваа нэгэн хориг хязгаарлалт байхгүйгээр Монгол Улсад гаргасан өргөдөл хүсэлтийн дагуу дизелийн түлшийг нийлүүлэхэд бэлэн байгаа нийлүүлж байгаа гэдгээ мэдэгдсэн болно. Тийм учраас ойрын хугацаанд асуудал шийдэгдэх байх. Сая бас Засгийн газар хоорондын комиссын шинэ дарга нар яригдаж өргөн хүрээтэй асуудлаар ярилцсан байгаа. Одоо энэ асуудал яригдаж байгаа. Тэгээд өнөөдөр бол ингээд дизель түлшнүүд хилээр орж ирж байна.

Д.Цогтбаатар: Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаас ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас Хунанг чөлөөлөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Чөлөөлөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд 70 хувиар санал дэмжигдлээ.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргыг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж танилцуулна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

11.48 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ